

ХОВД АЙМГИЙН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, АУДИТЫН АЛБА

**САНХҮҮГИЙН ХЯНАЛТ АУДИТЫН ДУНД ХУГАЦААНЫ  
СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ**

2018-2020 он

## **АГУУЛГА**

- **ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН МЭДЭГДЭЛ**
- **ҮНДЭСЛЭЛ, АРГА ЗҮЙ**
- **БАЙГУУЛЛАГЫН ТҮҮХЭН ТОВЧОО**
- **БАЙГУУЛЛАГЫН АЛСЫН ХАРАА, ЭРХЭМ ЗОРИЛГО, БАРИМТЛАХ ЗАРЧИМ, СТРАТЕГИ ЗОРИЛТУУД, ҮНЭТ ЗҮЙЛС**
- **САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДОТООД АУДИТЫН ХАМРАХ ХҮРЭЭ, ЧИГЛЭЛ**
- **ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ**
- **САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН АРГАЧЛАЛ**

## ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН МЭДЭГДЭЛ

Төсвийн тухай хуулийн дагуу Ховд аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны 2017-2020 оны үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөөг боловсруулан СХААлбанаас төсвийн Ерөнхийлөн захирагч бөгөөд аймгийн Засаг даргад өргөн мэдүүлж байна. Энэхүү төлөвлөгөө нь:

- Санхүүгийн хяналт, аудитын албаны стратеги /алсын хараа, эрхэм зорилго, эрхэмлэх зарчим 2017-2020 онд дэвшүүлж буй стратегийн зорилтууд/
- Аймгийн Засаг даргад Санхүүгийн хяналт, аудитын албаны хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ, тэдгээрийн шалгуур үзүүлэлт
- Санхүүгийн хяналт, аудитын албаны боловсон хүчин, санхүү, материаллаг нөөцийн чадавхийг дээшлүүлэх, эд хөрөнгийг ашиглах хамгаалахтай холбогдсон зорилтууд
- Төсвийн орлого, зарлага, орцыг төсөвлөсөн тайлан зэргийг багтаасан болно.

Төлөвлөгөөнд тусгагдсан дунд хугацааны зорилго, зорилт, хүрэх үр дүнг хангахаар хэрэгжүүлж буй хөтөлбөр, арга хэмжээ нь аймгийн хөгжлийг хангах болон Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилтыг биелүүлэхэд шууд чиглэгдэж хувь нэмэр оруулна.

Аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албанаас хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг тогтвортой мөрдөж, тухайн жилд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг шалгуур үзүүлэлт бүрээр хүрэх үр дүн, өртөг, түүнд шаардагдах төсвийн зардлын төлөвлөгөөг Засаг даргатай урьдчилан тохиролцооноор жил бүр тодотгон батлуулан ажиллана.

Төлөвлөгөөний биелэлтийг жил бүр аймгийн Засаг дарга бөгөөд төсвийн ерөнхийлөн захирагчид тайлагнах, хүрсэн түвшинг улам баталгаажуулах, тогтвортой ахиулах, шинжилгээ үнэлгээ хийж удаашралтай байгаа үйл ажиллагааны хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар мэргэжилтэн, ажилтан, албан хаагчдыг үүрэг даалгавар, арга зүйн зөвлөмжөөр ханган ажиллаж, Санхүүгийн хяналт аудитын албаны үйл ажиллагаа, түүний үр дүнгийн талаар аймгийн иргэдэд нээлттэй мэдээлж байх болно.

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, АУДИТЫН АЛБАНЫ ДАРГА  
БӨГӨӨД ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

Б.НАРМАНДАХ

## **I. ҮНДЭСЛЭЛ, АРГА ЗҮЙ**

### **1.1 Нийтлэг үндэслэл**

Ховд аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба нь Монгол Улсын хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гарсан дүрэм журам, норм, норматив, стандартын хэрэгжилтийг хангуулж, санхүүгийн сахилга батыг бэхжүүлэх, төсөв санхүүгийн хяналт шалгалтыг үр дүнтэй байдлаар хэрэгжүүлэх, хяналт шалгалтын чиг үүргийг олон нийтэд хууль эрх эүйн хүрээнд хүнд суртал чирэгдэлгүй түргэн шуурхай хүргэх, мэдээллээр хангах, зөрчил дутагдлаас урьдчилан сэргийлэх чиглэлээр тухайн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлэх асуудлыг хамарсан үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын хэтийн чиглэлийг тодорхойлов.

Төлөвлөгөөг боловсруулахдаа Засгийн газар болон Сангийн яамны Төсвийн хяналт, эрсдэлийн удирдлагын газар, Аймгийн Засаг даргын Тамгын газар болон холбогдох дээд байгууллагын удирдлага, үйл ажиллагааны төлөвлөгөө, байгууллагын бүтэц арга зүйн хүрээнд боловсрууллаа.

Санхүүгийн хяналт, аудитын албаны 2018-2020 оны дунд хугацааны төлөвлөгөөнд үйл ажиллагааны гол зорилго, цар хүрээг тусгасан ба эдгээрийг байгууллагын дүрэмд тусгагдсан байгууллагын зорилго, үйл ажиллагааны чиглэлд нийцүүлэн тодорхойллоо.

### **1.2 Дунд хугацааны төлөвлөгөөг шинэчлэх**

Байгууллагын дунд хугацааны төлөвлөгөөг жил бүр хянаж, байгууллагын зорилго, үндсэн чиглэл ба үйл ажиллагаанд гарсан өөрчлөлтүүд, эрсдэлийн үнэлгээ зэргийг тусгахын тулд байнга шинэчлэнэ.

### **1.3 Байгууллагын чиг үүрэг**

Санхүүгийн хяналт, аудитын алба нь аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, нийгэм эдийн засгийн зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хууль тогтоомжийн хэрэгжилтэнд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтанд хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж өгөх, эрсдэлийн удирдлагаар хангах чиглэлээр төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлэх үүргийг албаны дүрмээр хүлээн ажиллаж байна.

## II. БАЙГУУЛЛАГЫН ТҮҮХЭН ТОВЧОО


Ховд аймгийн Санхүүгийн хяналт аудитын алба нь Монгол улсын засгийн газрын 2014 оны 327 дугаар тогтоол, Аймгийн засаг даргын 2014 оны 11-р сарын 10-ны өдрийн А/577 тоот захирамжаар байгуулагдсан. Албаны дарга-1, Ахлах байцаагч-1, Байцаагч-4 орон тоотой үйл ажиллагаагаа явуулж байна.

Санхүүгийн хяналт, аудитын алба нь бүтэц зохион байгуулалт, материаллаг бааз, мэргэшсэн боловсон хүчний хувьд бэхжиж, хяналт шалгалтыг төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх хүрээний байгууллагуудад үзүүлэн зөрчил дутагдлыг давтан гаргахаас сэргийлэн ажиллаж байна.

### 2.1 Байгууллагын эрхэм зорилго

Хууль тогтоомжийн хэрэгжилт, төсвийн хөрөнгө, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангах чиглэлээр тухайн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлэхэд оршино.

### 2.2 Байгууллагын бүтэц



### 2.3 Байгууллагын дотоод хяналт, зохион байгуулалт

Байгууллагын удирдлага нь санхүүгийн хяналт, аудитын ажлыг зохистойгоор хянаж, удирдах үүргийг хүлээнэ. Санхүүгийн хяналт, аудитын ажлыг хянаж, удирдах үйл явц нь аудитын ажлын төлөвлөлт, гүйцэтгэл ба

тайлагнал, аудитын зөвлөмжийн хэрэгжилтийн мөрөөр гүйцэтгэлийн хяналт шалгалт, аудитын ажлын бүх үе шатанд хэрэгжинэ.

Санхүүгийн хяналт, аудитын ажлыг хянаж удирдах үйл явцад дараах үйл ажиллагаанууд багтана.

- Ажилтан тухайн санхүүгийн хяналт шалгалт, аудитын ажлыг гүйцэтгэх мэдлэг, ур чадвар, дадлага туршлага, харилцааны соёлтой эсэхийг харгалзан үзэх;
- Санхүүгийн хяналт шалгалт, аудитын ажлын төлөвлөлтийн үе шатанд зааварчилгаагаар хангах;
- Санхүүгийн хяналт шалгалт, аудитын ажлын төлөвлөгөөг хянаж батлах;
- Санхүүгийн хяналт шалгалт, аудитын ажил батлагдсан төлөвлөгөөний дагуу хэрэгжиж байгаа эсэхийг хянах;
- Санхүүгийн хяналт шалгалт, аудитын ажлын баримт нь шалгалтаар илэрсэн асуудлууд, дүгнэлт, зөвлөмжийг хууль эрхзүйн хүрээнд байгаа эсэхийг шалгах;
- Санхүүгийн хяналт шалгалт, аудитад хамрагдсан байгууллагын удирдлага ба шалгалтын багийн хоорондын харилцаа зүй зохистойгоор явагдсан эсэхийг авч үзэх;
- Санхүүгийн хяналт шалгалт, аудитын ажлын зорилго хангагдсан эсэхийг хянах;

#### 2.4 Харилцах байгууллагууд:

- Төсвийн Ерөнхийлөн захирагчийн хүрээний байгууллагууд;
- Монголын Мэргэшсэн нягтлан бодогчдын Салбар зөвлөл;
- Ховд аймгийн Аудитын газар;
- Аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй төрийн болон төсвийн бүх байгууллагууд;
- Төсвөөс санхүүжилт авсан, гэрээ байгуулан хамтран ажиллаж буй байгууллагууд;

### **III. БАЙГУУЛЛАГЫН АЛСЫН ХАРАА, ЭРХЭМ ЗОРИЛГО, БАРИМТЛАХ ЗАРЧИМ, СТРАТЕГИ ЗОРИЛТУУД, ҮНЭТ ЗҮЙЛС**

#### **АЛСЫН ХАРАА:**

Санхүүгийн хяналт, Дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандартуудын хүрээнд үйл ажиллагаагаа явуулж, сайн туршлагыг нэвтрүүлсэн, улсын салбарын дотоод аудитын үйл ажиллагааны үр дүн, чанараар тэргүүлэгч хамт олон болох.

#### **ЭРХЭМ ЗОРИЛГО:**

Монгол улсын хууль тогтоомжийг сахиулан, санхүүгийн сахилга батыг бэхжүүлэхэд санхүүгийн хяналт шалгалт, аудитын эрхэм зорилго оршино.

#### **БАРИМТЛАХ ЗАРЧИМ:**

- Шударга байх, хуулиа дээдлэх, ил тод байх:
- Улс төрөөс ангид байх:
- Шуурхай, бүтээмжтэй байх:
- Мэдлэг чадварыг эрхэмлэх:
- Тогтвортой, баталгаатай байх

#### **СТРАТЕГИ ЗОРИЛТУУД:**

Байгууллагын эрхэм зорилго, үндсэн чиглэл болон үйл ажиллагаа, дотоод хяналтын талаарх мэдээлэл дээр үндэслэн байгууллагын 2018-2020 онд хамаарах стратеги зорилгуудыг тодорхойлов.

**3.1 Санхүүгийн хяналт, дотоод аудитын тогтолцоог боловсронгуй болгох:** Аймгийн санхүүгийн хяналт, дотоод аудитын дунд хугацааны стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, байгууллагын хөрөнгө, санхүүгийн бааз суурийг бэхжүүлэх, удирдлага зохион байгуулалтын үр нөлөөтэй бодлого хэрэгжүүлэх;

**3.2 Мэргэшсэн санхүүгийн хяналтын улсын байцаагч, дотоод аудиторыг бэлтгэх:** Албан хаагчдын мэргэшил, мэдлэгийг дээшлүүлэх, чадавхжуулах тасралтгүй сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх. Улсын салбарын мэргэшсэн дотоод аудиторын сургалтанд хамрагдаж, мэргэшсэн дотоод аудитор бэлтгэх

**3.3 Санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудитын үйл ажиллагааг чанартай үзүүлэх:** Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, орон нутгийн

тусгай зориулалтын сангууд, төсөл хөтөлбөр, төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөгдөж буй хууль тогтоомжийн хэрэгжилтэнд санхүүгийн хяналт, шалгалт хийж илэрсэн зөрчил дутагдалд хариуцлага тооцох, хэрэгжилтийг хангуулах, мэргэжлийн зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх;

**3.4 Төсвийн шууд захирагчийн дотоод аудитын ажилтан нарыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах:** Санхүүгийн хяналт, аудитын дотоод үйл ажиллагаанд чанарын баталгаажуулалт хийлгэх, дотоод аудитын ажилтан нарыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;

**3.5 Санхүүгийн хяналт, дотоод аудитын эрсдлийн удирдлагын ойлголт түүний ач холбогдол, үр дүнг олон нийтэд таниулан сурталчлах:** Эрсдэлийн тухай ойлголт, санхүүгийн хяналт аудитын үйл ажиллагааг ач холбогдол, үр дүнг байгууллага, түүний ажилтнууд, иргэд олон нийтэд таниулах, сурталчлах;

## **СТРАТЕГИ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД ХИЙГДЭХ АЖЛУУД:**

Санхүүгийн хяналт, дотоод аудитыг 2018-2020 онд хөгжүүлэх дунд хугацааны төлөвлөгөөнд үндэслэн албаны тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэн ажиллах болно. Хавсралт №01

3.1 Санхүүгийн хяналт, дотоод аудитын тогтолцоог боловсронгуй болгох

3.1.1 Аймгийн дотоод аудитын хороог зохих түвшинд байгуулж, үйл ажиллагааг жигдрүүлэх

3.1.2 Санхүүгийн хяналт, аудитын ажилтны нийгмийн баталгааг хангах, тэдгээрийг тогтвор суурьшилтай ажиллуулахад дэмжлэг үзүүлэх

3.1.3 Орон тоог нэмэгдүүлэх, төсвийн зохицуулалт хийх

3.2 Мэргэшсэн санхүүгийн хяналтын улсын байцаагч, дотоод аудиторыг бэлтгэх

3.2.1 Дотоод аудитын үндсэн мэдлэг олгох сургалтанд СХШ-ын улсын байцаагч нарыг бүрэн хамруулах

3.2.2 Улсын салбарын мэргэшсэн дотоод аудиторын давтан сургалтанд СХШ-ын улсын байцаагч, аудиторуудыг бүрэн хамруулах

3.2.3 Төсвийн шууд захирагчдын дотоод аудитын нэгжийн ажилтанг сургалтанд хамруулах

3.2.4 Төсвийн шууд захирагчдын дотоод аудитын нэгжийн ажилтаны нэгдсэн мэдээллийн сан бүрдүүлэх, баяжуулах



### 3.3 Санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудитын үйл ажиллагааг чанартай үзүүлэх

3.3.1 Аймгийн тусгай сангуудын үйл ажиллагаанд санхүүгийн хяналт, дотоод аудитыг аргачлал, стандартын дагуу мэргэжлийн түвшинд үзүүлэх

3.3.2 Төсөвт байгууллагуудын үйл ажиллагаанд санхүүгийн хяналт, дотоод аудитыг аргачлал, стандартын дагуу мэргэжлийн түвшинд үзүүлэх

3.3.3 Төрийн өмчийн болон орон нутгийн өмчийн компаниудын үйл ажиллагаанд санхүүгийн хяналт, дотоод аудитыг аргачлал, стандартын дагуу мэргэжлийн түвшинд үзүүлэх

3.3.4 Төрийн өмчийн оролцоотой байгууллагуудын үйл ажиллагаанд санхүүгийн хяналт, дотоод аудитыг аргачлал, стандартын дагуу мэргэжлийн түвшинд үзүүлэх

3.3.5 Төсөвт болон төрийн өмчит байгууллага, тусгай сангуудад эрсдэлийн үнэлгээний аргачлалын дагуу үнэлгээ хийх, эрсдлийн үнэлгээ хийх аргачлалыг нэвтрүүлэх, үр дүнг тооцох

3.3.6 Төсөвт болон төрийн өмчит байгууллага, тусгай сангуудын эрсдэлийн бүртгэлийн санг бий болгох, баяжуулах

### 3.4 Төсвийн шууд захирагчийн дотоод аудитын ажилтан нарыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах

3.4.1 Төсвийн шууд захирагчийн дотоод аудитын ажилтнуудад сургалт сурталчилгаа зохион байгуулах.

### 3.5 Санхүүгийн хяналт, дотоод аудитын эрсдлийн удирдлагын ойлголт түүний ач холбогдол, үр дүнг олон нийтэд таниулан сурталчилах

3.5.1 Санхүүгийн хяналт, дотоод аудит, эрсдлийн удирдлагыг олон нийтэд сурталчилах төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх

3.5.2 Иргэний нийгмийн байгууллагын оролцоог нэмэгдүүлэх

### **ҮНЭТ ЗҮЙЛС:**

- Мэргэшсэн өндөр мэдлэг чадвар
- Шинэ санаачилга
- Үнэнч шударга зарчим, ёс зүй
- Хараат бус байдал

### **ХҮРЭХ ҮР ДҮН:**

1. Албаны үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй, ил тод, нягтлан бодох

бүртгэлийн олон улсын стандартууд, хууль тогтоомжийн хүрээнд эрхлэн явуулж, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байна.

2. Санхүүгийн хяналт шалгалтаар эрсдэл ихтэй үнэлэгдсэн байгууллагад хийх хяналт шалгалтыг чангатгаж эрсдэлийг бууруулах арга хэмжээг авч хэвшүүлнэ.

3. Улсын байцаагч нарыг хөгжүүлэх мэргэжлийн болон бусад чиглэлийн сургалтуудыг зохион байгуулах, гадаад, дотоодын сургалтуудад хамруулж мэдлэг мэргэжлийг дээшлүүлж чадварлаг хүний нөөцтэй болно.

4. Дотоод аудитын стандартыг нэвтрүүлж, чанарын баталгаажуулалт хийгдэнэ. Аймагтаа дотоод аудитын талаар сурталчилан таниулах, төсвийн шууд захирагчийн дотоод аудитын ажилтнуудад мэргэжил арга зүйн тусламж үзүүлж, дотоод аудитын хүний нөөц бааз суурийг нэмэгдүүлсэн байна.

5. Санхүүгийн хяналт Дотоод аудит, эрсдэлийн тухай ойлголт, санхүүгийн хяналт аудитын ач холбогдол, үр дүнгийн талаарх мэдээллийг байгууллага, иргэд олон нийтэд шуурхай хүргэх, удирдлагыг мэдээллээр хангах

#### **IV. САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДОТООД АУДИТЫН ХАМРАХ ХҮРЭЭ, ЧИГЛЭЛ**

Монгол улсын Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйл, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолыг үндэслэн төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдийг хамруулна. Санхүүгийн хяналт шалгалт, аудитыг дараах чиглэлээр хийж гүйцэтгэнэ.

- Санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэлийн холбогдолтой хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр болон түүнийг үндэслэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан заавар, журмын хэрэгжилт;
- Тухайн байгууллагын орлогын төлөвлөлт, төвлөрүүлэлт, төсөвт хөрөнгийн зарцуулалт;
- Өмч, хөрөнгийн ашиглалт, зарцуулалт, хадгалалт, хамгаалалт;
- Санхүүгийн үйл ажиллагааны үр дүн, үр ашгийн байдал;
- Төсвийн хөрөнгө оруулалтын ашиглалт, зарцуулалт;
- Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, санхүүгийн тайлан;
- Байгууллагын нягтлан бодогчийн хууль тогтоомжид заасан үүргийн биелэлт.

## V. ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

### 5.1 Тодорхойлсон эрсдлүүд

1. Төсвийн ил тод байдал, иргэд байгууллагын санал, мэдээлэл
2. Санхүү, төсвийн удирдлага
3. Байгууллагын дотоод хяналт, аудитор
4. Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт
5. Орлого төвлөрүүлэлт
6. Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, ашиглалт, зарцуулалт
7. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээг худалдан авах үйл ажиллагаа
8. Өмнөх хяналт шалгалтын түүх гэсэн найман шалгуур үзүүлэлтээр эрсдлийг тодорхойлно.

### 5.2 Эрсдэлийг хэмжиж үнэлэх

Эрсдлийг хэмжихэд тухайн байгууллагын үйл ажиллагааг 8 шалгуур үзүүлэлтээр 1-10 оноогоор үнэлнэ.

### 5.3 Эрсдэлийг ач холбогдлоор нь зэрэглэх

Найман шалгуур үзүүлэлтийн нийт оноо 0-24 бол бага эрсдэлтэй, 25-39 оноо дунд эрсдэлтэй, 40-өөс дээш оноотой бол их эрсдэлтэй гэж үзнэ.

Санхүүгийн хяналт, дотоод аудит хийгдэх объектыг Их, Дунд ба Бага эрсдэлтэй гэж ач холбогдлоор нь зэрэглэхэд байгууллагын даргын баталсан “Эрсдэлийн үнэлгээ хийх заавар”-ыг ашигласан болно.

## VI. САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН АРГАЧЛАЛ

### 6.1 Санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудит хийх давтамж

**Их эрсдэлтэй:** Жилд нэг удаа

**Дунд эрсдэлтэй:** Хоёр жилд нэг удаа

**Бага эрсдэлтэй:** Гурван жилд нэг удаа

Төсөв	Эрсдлийн түвшингээр, ажиллах хүн өдөр		
	Их	Дунд	Бага
1,000,0 сая төг- өөс дээш	30-аас доошгүй	25	25
500,0-1,000,0 сая.төг	25 хүртэл	20	20
500,0 сая.төг хүртэл	20 хүртэл	15 хүртэл	15 хүртэл

Зөвлөмжийн хэрэгжилтийн мөрөөр гүйцэтгэлийн хяналт хийх - Зөвлөмжийн хэрэгжилтийн мөрөөр гүйцэтгэлийн хяналтыг хэрэгжүүлэхэд нэг объектэд 1-ээс

3 хүн/өдөр зарцуулна.

## 6.2. Хяналт шалгалтын ажилтны ажил үүргийн хуваарилалт

Байгууллагын ажилтан бүрт ажил үүргийг дараах байдлаар хуваарилна.

- Нийт хүн өдрийн 60%-80%-ийг санхүүгийн хяналт, дотоод аудитын баталгаажуулах ажил, дунд хугацааны ба жилийн төлөвлөлтийн ажилд зарцуулах;
- Нийт хүн-өдрийн 15%-30%-ийг байгууллагын дотоод үйл ажиллагаанд зарцуулах;
- Нийт хүн-өдрийн 5%-10%-ийг мэдлэг, боловсрол дээшлүүлэх сургалт, семинар гэх мэт бусад төрлийн үйл ажиллагаанд зарцуулахаар тооцсон.

БОЛОВСРУУЛСАН:

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ АУДИТЫН  
АЛБАНЫ ДАРГА

Б.НАРМАНДАХ

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН  
УЛСЫН БАЙЦААГЧ

Ц.БАДРАЛ

## ХОВД АЙМГИЙН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ АУДИТЫН АЛБЫГ 2018-2020 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ДУНД ХУГАЦААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

	Стратегийн зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хүрэх үр дүн	Хариуцах байгууллага	Хэлэгжих хугацаа
<b>Стратеги зорилт 1. Санхүүгийн хяналт, дотоод аудитын тогтолцоог боловсронгуй болгох</b>					
1.1	Санхүүгийн хяналт, дотоод аудитын бие даасан, хараат бүс байдлыг бэхжүүлэх	1.2.1 Аймгийн дотоод аудитын хороог зохих түвшинд байгуулж, үйл ажиллагааг жигдрүүлэх	Санхүүгийн хяналт, дотоод аудитын хороо байгуулагдсан, үйл ажиллагаа жигдэрсэн байх	Аймгийн Засаг дарга, СХААлба	2018-2020 он
		1.2.2 Санхүүгийн хяналт, аудитын ажилтны нийгмийн баталгааг хангах, тэдгээрийг тогтвор суурьшилтай ажиллуулахад дэмжлэг үзүүлэх	Ажилтны нийгмийн баталгаа хангагдсан, томилох, чөлөөлөхөд эрх нь хамгаалагдсан байх		2018-2020 он
		1.2.3 Орон тоог нэмэгдүүлэх, төсвийн зохицуулалт хийх	Ажлын ачаалал бүүрч, хяналт аудитын хамрах хүрээ нэмэгдсэн байх	Дотоод Аудитын хороо	2018-2020 он
<b>Стратеги зорилт 2. Мэргэшсэн санхүүгийн хяналтын улсын байцаагч, дотоод аудиторыг бэлтгэх</b>					
2.1	Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч нарыг үе шаттайгаар зохион байгуулах	2.1.1. Дотоод аудитын үндсэн мэдлэг олгох сургалтанд СХШ-ын улсын байцаагч нарыг бүрэн хамруулах	СХШ-ын улсын байцаагч нар бүрэн хамрагдсан байх	Аймгийн Засаг дарга, СХААлба	2018-2020 он
		2.1.2. Улсын салбарын мэргэшсэн дотоод аудиторын давтан сургалтанд СХШ-ын улсын байцаагч, аудиторуудыг бүрэн хамруулах	СХШ-ын улсын байцаагч, дотоод аудиторууд бүрэн хамрагдсан байх		
2.2	Төсвийн шүүд захирагчдын дотоод аудитын нэгжийн ажилтанг мэргэшүүлэх, тэдгээрийн мэдээллийн санг бүрдүүлэх	2.2.1 Төсвийн шүүд захирагчдын дотоод аудитын нэгжийн ажилтанг сургалтанд хамруулах,	Төсвийн шүүд захирагчдын дотоод хяналтын ажилтангуудын 70 хувь нь хамрагдсан байх	Санхүүгийн хяналт, аудитын алба	2018-2020 он
		2.2.2 Төсвийн шүүд захирагчдын дотоод аудитын нэгжийн ажилтаны нэгдсэн мэдээллийн сан бүрдүүлэх, баяжуулах	Мэдээллийн сан бий болсон байх		
<b>Стратеги зорилт 3. Санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудитын үйл ажиллагааг чанартай үзүүлэх</b>					
3.1	Тухайлсан байгууллага болон салбарын онцлогт тохирсон дотоод аудитын аргачлалыг нэвтрүүлэх	3.1.1 Тухайлсан байгууллага болон салбарын онцлогт тохирсон дотоод аудитын аргачлал боловсруулахад санал бэлтгэн Сангийн яаманд хүргүүлэн ажиллах	Дотоод аудитыг гүйцэтгэх аргачлал заавар батлагдсан байх	Сангийн яам, СХААлба	2018-2020 он

3.2	Санхүүгийн хяналт, дотоод аудитын үйл ажиллагааг мэргэжлийн түвшинд үзүүлэх	3.2.1 Аймгийн тусгай сангуудын үйл ажиллагаанд санхүүгийн хяналт, дотоод аудитыг аргачлал, стандартын дагуу мэргэжлийн түвшинд үзүүлэх	Батлагдсан аргачлал стандартыг хэрэгжүүлэн дотоод аудитыг гүйцэтгэн тухайн байгууллагын үнэ цэнэ нэмэгдүүлсэн байх	Санхүүгийн хяналт, аудитын алба	2018-2020 он
		3.2.2 Төсөвт байгууллагуудын үйл ажиллагаанд санхүүгийн хяналт, дотоод аудитыг аргачлал, стандартын дагуу мэргэжлийн түвшинд үзүүлэх			
		3.2.3 Төрийн өмчийн болон орон нутгийн өмчийн компаниудын үйл ажиллагаанд санхүүгийн хяналт, дотоод аудитыг аргачлал, стандартын дагуу мэргэжлийн түвшинд үзүүлэх			
		3.2.4 Төрийн өмчийн оролцоотой байгууллагуудын үйл ажиллагаанд санхүүгийн хяналт, дотоод аудитыг аргачлал, стандартын дагуу мэргэжлийн түвшинд үзүүлэх			
3.3	Эрсдэлийн удирдлагын тогтолцооны суурийг тавих	2.3.1. Төсөвт болон төрийн өмчит байгууллага, тусгай сангуудад эрсдэлийн үнэлгээний аргачлалын дагуу үнэлгээ хийх, эрсдлийн үнэлгээ хийх аргачлалыг нэвтрүүлэх, үр дүнг тооцох	Төрийн байгууллагууд эрсдэлээ тодорхойлж, үнэлдэг болсон байх	Санхүүгийн хяналт, аудитын алба	2018-2020 он
		2.3.2. Төсөвт болон төрийн өмчит байгууллага, тусгай сангуудын эрсдэлийн бүртгэлийн санг бий болгох, баяжуулах.	Төрийн байгууллагын эрсдэлийн бүртгэлийн нэгдсэн сантай болсон байх	Санхүүгийн хяналт, аудитын алба	2018-2020 он
<b>Стратеги зорилт 4. Төсвийн шууд захирагчийн дотоод аудитын ажилтан нарыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах</b>					
4.1	Төсвийн шууд захирагчийн дотоод аудитын ажилтан нарыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах	4.1.1 Төсвийн шууд захирагчийн дотоод аудитын ажилтануудад сургалт сурталчигаа зохион байгуулах.	Дотоод аудитын чиглэлээр тодорхой түвшний мэдлэгтэй болсон байна.	Санхүүгийн хяналт, аудитын алба	2018-2020 он
<b>Стратеги зорилт 5. Санхүүгийн хяналт, дотоод аудитын эрсдлийн удирдлагын ойлголт түүний ач холбогдол, үр дүнг олон нийтэд таниулан сурталчилах</b>					
5.1	Санхүүгийн хяналт, дотоод аудитын эрсдлийн удирдлагын ач холбогдол, хэрэгцээ шаардлагыг олон нийтэд хүргэх	5.1.1 Санхүүгийн хяналт, дотоод аудит, эрсдлийн удирдлагыг олон нийтэд сурталчилах төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх	Санхүүгийн хяналт, дотоод аудит, эрсдлийн удирдлагын ач холбогдолын талаарх мэдлэг мэдээлэл ард олон нийтэд хүрсэн байх	Санхүүгийн хяналт, аудитын алба	2018-2020 он
		5.1.2 Иргэний нийгмийн байгууллагын оролцоог нэмэгдүүлэх	Иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажиллаж, тодорхой үр дүнд хүрсэн байх	Санхүүгийн хяналт, аудитын алба	2018-2020 он

ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛСАН: АЛБАНЫ ДАРГА

Б.НАРМАНДАХ